БАТЛАВ.
НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН
ГАЗРЫН ДАРГА П. БАТХҮЛЭГ

2019 оны... дугаар сарын...27

УХА0596 5131448
116128632

## НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН
## "ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР"-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
## 2019 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Үндсэн үйл ажиллагаа | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | | |
|---|---|---|---|---|
| | | Хугацаа | Хамрах хүрээ | Хүрэх үр дүн |
| **Хөтөлбөрийн зорилт 1**<br>Хүний нөөцийн удирдлагын менежментийг сайжруулах ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | | | | |
| 1.2 | Хүний нөөцийн асуудлаар гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээ авч ажиллах | 2017-2021 он | Удирдах ажилтнууд | Яам, агентлаг, нийслэл, аймгийн хүрээнд байдаг гадаад хамтын ажиллагаанд хүний нөөцийн хөгжлийн асуудал тусгана. |
| **Хөтөлбөрийн зорилт 2**<br>Төрийн бодлого зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | | | | |
| 2.1 | Бүх шатны удирдлага болон бусад албан тушаалтнуудад стратеги төлөвлөлт, гүйцэтгэлийн менежмент, бодлогын дүн шинжилгээ, мониторинг үнэлгээ хийх зэрэг асуудлаар мэдлэг чадвар бий болгох арга хэмжээ авах, хэрэгжүүлэх болон төлөвшүүлэх ажлыг зохион байгуулах | 2017-2019 он | Хариуцсан ажилтнууд | Бүх шатны удирдлага болон бусад албан тушаалтнуудад стратеги төлөвлөлт, гүйцэтгэлийн менежмент,бодлогын дүн шинжилгээ, мониторинг үнэлгээ хийх зэрэг асуудлаар мэдлэг чадвар бий болгох сургалт зохион байгуулж, дадлага эзэмшүүлж, өөрийн гэсэн чадвартай болоход нь дэмжлэг үзүүлсэн байна. |
| **Хөтөлбөрийн зорилт 3**<br>Удирдах албан тушаалтнуудын манлайллын чадавхийг хөгжүүлэх ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | | | | |
| 3.2 | Байгууллагын дотоод болон гадаад орчны хүрээнд үр бүтээлтэй ажлын харилцааг бий болгох | 2018-2019 он | Нийт гүйцэтгэх болон удирдах албан тушаалтнууд | Байгууллагын гадаад, дотоод орчны харилцаа сайжирч энэ хүрээнд шинэлэг ажил, үйлчилгээг зохион байгуулсан байна. |
| **Хөтөлбөрийн зорилт 4** | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Хүний нөөцийн удирдлагад “Өөрчлөлт” хийх зан үйлийн хандлагад тасралтгүй суралцах ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | | | | |
| 4.1 | Менежерүүд “Хүний нөөцийн удирдлага”-ын чиглэлээр мэдлэг чадвараа тасралтгүй хөгжүүлэх, шинэ мэдээ мэдээлэл, аргачлалыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх | 2017-2024 он | Удирдах ажилтнууд | Шинэ мэдээ мэдээлэл, аргачлалыг. үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, бодлого боловсруулах болон арга зүйн зөвлөмж өгөхөд ашигласан байх |
| **Хөтөлбөрийн зорилт 5**<br>Чиг үүргийг хэрэгжүүлэх боловсон хүчний хэрэгцээг тодорхойлж, хангах ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | | | | |
| 5.3 | Хүний нөөцийн тоо байршил, ур чадварын зохистой харьцааг хангах замаар үр дүнтэй нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх | 2019 он | Удирдах ажилтнууд | Хүний нөөцөөр дамжуулан нийгмийн халамжийн үр дүнтэй үйлчилгээг үзүүлсэн байна. |
| **Хөтөлбөрийн зорилт 6**<br>Албан хаагчдыг хөгжүүлэх, карьер өгсөх стратеги хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | | | | |
| 6.3 | Албан хаагчдыг өөрчлөн байршуулах, карьер өсгөх тогтолцоог бүрдүүлэх | 2019 он | Удирдах ажилтнууд | Албан хаагчдыг өөрчлөн байршуулсан болон карьер өссөн тоо |
| 6.4 | Удирдах албан тушаалтны нөөц бүрдүүлэх | 2019 он | Удирдах ажилтнууд | Удирдах албан тушаалтанд ямар нэгэн асуудал тохиолдоход түүнийг орлох чадвартай мэргэжилтэн бэлтгэгдсэн байх |
| 6.5 | Тухайн хүнийг хөгжүүлэх хэрэгцээг байгууллагын тэргүүлэх чиглэл, өөрчлөлтөд уялдуулан тодорхойлох | 2019 он | Удирдах ажилтнууд | Ажилтныг хөгжүүлэх чиглэлээр тодорхой сургалт, арга хэмжээ зохион байгуулсан байна. |
| 6.6 | Тухайн ажилтныг зөв үнэлж дүгнэх, ур чадварын хөгжлийн хэрэгцээний хангалтыг зохион байгуулах | 2019 он | Удирдах ажилтнууд | Тухайн ажилтныг зөв үнэлж, дүгнэх арга барилыг эзэмшиж, ажилтан бүрийг ижил аргачлалаар үнэлж дүгнэдэг байх |
| **Хөтөлбөрийн зорилт 7**<br>Хүний нөөцийг эрсдэлийн удирдлагаар хангах ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 7.1 | Эрсдэлийн удирдлагын талаар холбогдох ажилтнууд мэдлэг чадвараа дээшлүүлэх | 2019 оны 1 дүгээр улирал | Удирдах ажилтнууд | Эрсдэлийн удирдлагын тухай мэдлэг чадвартай болгох зорилгоор сургалт зохион байгуулсан байна. |
| 7.2 | Төрийн албан хаагчдын тогтвортой, мэргэшсэн байх зарчим хангагдах механизм бүрдүүлэх | 2019 оны 2 дугаар улирал | Удирдах ажилтнууд | Төрийн албан хаагчдын шилжилт хөдөлгөөн тодорхой хувиар буурсан байна. |
| 7.3 | Мэргэшсэн, чадавхтай албан хаагчдыг хадгалж үлдэх стратегийг сайжруулах | 2019 оны 3 дугаар улирал | Удирдах ажилтнууд | Тогтвор суурьшилтай ажиллаж буй албан хаагдын тоо тодорхой хувиар нэмэгдсэн байна. |
| 7.4 | Албан хаагчдад хөрвөх, сэлгэх, нөхөн ажиллах, хавсарч ажиллах чадавх бий болгох | 2019 оны 4 дүгээр улирал | Бүх албан хаагчид | Албан хаагчдын хөрвөх чадвартай, нэг албан тушаалаас нөгөөд шилжиж, орлох чадвартай болсон байна. |
| 7.5 | Ажилтнуудад давхар мэргэжил, ур чадвар бий болгох | 2019 оны 1 дүгээр улирал | Бүх албан хаагчид | Мэргэшүүлэх сургалтад хамруулж, хөрвөх чадвартай ажилтанг бэлтгэсэн байна. |
| **Хөтөлбөрийн зорилт 11**<br>Ажиллагсдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаагаар хангах механизм төлөвшүүлэх ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | | | | |
| 11.1 | Ажилтнуудыг материаллаг бааз, техник хэрэгслээр хангах | 2019-2024 он | Удирдах ажилтнууд | Ажилтнуудыг материаллаг бааз, техник хэрэгслээр 100 хувь хангасан байна. |
| 11.2 | Ажлын байрны тохижилт, шинэчлэлт орчин үеийн жишигт нийцүүлэн тохижуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх | 2019-2024 он | Удирдах ажилтнууд | Ажлын байрыг гадаад орчны өөрчлөлттэй уялдуулан тохижуулж байх |
| 11.3 | Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах асуудлыг Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлж байх | 2019-2024 он | Удирдах ажилтнууд | Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу ажилтнуудын нийгмийн баталгааг хангах, ажилтнуудын тухайн салбарт ажилласан хугацаа, хийж бүтээсэн ажлын үр дүнгээр нийгмийн асуудлыг шийдвэрлэх журам боловсруулж хэрэгжүүлсэн байна. |
| 11.4 | Ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах, орон сууцаар хангах хөтөлбөр боловсруулах | 2019-2024 он | Удирдах ажилтнууд | Ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах, орон сууцаар хангах үйл ажиллагааг үе |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | шаттайгаар зохион байгуулж ажилласан байна. |
| **Хөтөлбөрийн зорилт 12**<br>Хүний нөөцийн хөгжлийн асуудлаар гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | | | | |
| 12.1 | Төрийн албаны зөвлөлтэй хүний нөөцийн хөгжлийн асуудлаар хамтран ажиллах механизм бий болгох | 2019-2023 он | Удирдах ажилтнууд | Төрийн албаны зөвлөлтэй хүний нөөцийн хөгжлийн асуудлаар хамтран ажиллах механизм бүрдсэн байна. |
| **Хөтөлбөрийн зорилт 13**<br>Хүний нөөцийн мэдээллийн системтэй болох ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | | | | |
| 13.1 | Хүний нөөцийн мэдээллийн програмтай болох | 2019-2020 он | Удирдах ажилтнууд | Хүний нөөцийн мэдээллийн санг орчин үеийн технологи програмын орчинд бий болгох |
| 13.2 | Хүний нөөцийн судалгаа, түүнд тавих хяналт ил тод байх | 2019 | Удирдах ажилтнууд | Хүний нөөцийн мэдээлэл ил тод болж, хяналт тавих арга зам нээлттэй болно. |
| **Хөтөлбөрийн зорилт 14**<br>Байгууллагын үйл ажиллагаа, хөгжлийг хүний нөөцийн хөгжилтэй холбох хандлага, түүнийг эрхэмлэн дээдлэх тогтолцоог бий болгох ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | | | | |
| 14.1 | "Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр"-ийг 2015-2023 онд тасралтай хэрэгжүүлэх. | 2017-2024 он | Удирдах ажилтнууд | Байгууллагын зорилт чиг үүргийн өөрчлөлттэй уялдуулан уг хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулж хэрэгжүүлнэ. |
| 14.2 | Байгууллагын зорилт, чиг үүргийн өөрчлөлттэй уялдуулан зохион байгуулалтын өөрчлөлт хийж, үүний дагуу уг хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж байх | 2017-2024 он | Удирдах ажилтнууд | Цаг үеийн өөрчлөлттэй уялдуулан тухай бүрт шинэчлэн ажилласан байна. |

ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА Г. ГАНТҮШИГ

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:
МЭРГЭЖИЛТЭН Т. ОДОНТОГОО